

МЭДЭЭЛЭЛ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН ТӨВИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

1. Тус төв нь Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас гаргасан бодлогын баримт бичгүүд, хөтөлбөр, төлөвлөгөө, Цагдаагийн ерөнхий газраас 2021 онд дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

2. Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн баталсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2021 онд хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээллэх, хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх баримт бичгийн жагсаалт”-ын дагуу 46 төрлийн 99 зүйл заалт, Төвийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 53 заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг ханган, биелэлт үр дүнг тооцон хагас, бүтэн жилээр тайлагнасан.

3. Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор төвийн даргын тушаалаар нийт 23 орон тооны бус ажлын хэсэг, баг, зөвлөлийг шинэчлэн байгуулж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажилласан.

4. Төвийн дөвийн даргын А/29 дугаар тушаалаар “Төрийн жинхэнэ алба хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүнгийн түвшинг үнэлэх журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хэсэг, А/38, А/52 дугаар тушаалаар “Үнэлгээний баг”-ийн ажлын хэсгийг тус тус байгуулан үнэлэгдвэл зохих 148 алба хаагчаас 136 алба хаагчийн үнэлгээг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 100 дугаар тушаалын 10 дугаар хавсралтын дагуу баталгаажуулж, дүнг Мэдээлэл, дүн шинжилгээ шуурхай удирдлагын албанд хүргүүлэн ажилласан.

5. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын үйл ажиллагаатай танилцах, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоо болон Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагч, хошууч генерал Ж.Болд, зөвлөлийн гишүүдийн хамт төвийн үйл ажиллагаатай танилцах үед Цагдаагийн ерөнхий газрын шуурхай удирдлагын штабын техник хэрэгслийн бэлэн байдлыг ханган, цахим уулзалтад төвийн алба хаагчид хамрагдсан.

6. “Цөөвөр” хэмээх цагагчин үхэр жилийн сар шинийн баяр, ахмадын баярыг тохиолдуулан байгууллагын 89 ахмад ажилчдад тус бүр 40,000 төгрөгийн тэтгэмжийг олгож, 2020-2021 онд цэргийн байнгын тэтгэвэрт гарсан 13 ахмад ажилтанд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.

7. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдал, өндөржүүлсэн бэлэн байдлын үед Монгол Улсын шадар сайд, Улсын онцгой комисс, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагч, ЦЕГ-ын Тэргүүн дэд дарга, Дэд дарга, Албаны даргаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр ажил, арга хэмжээг зохион байгуулж биелэлт, үр дүнг тооцон ажилласан.

8. Тайлангийн хугацаанд Цагдаагийн ерөнхий газар болон бусад байгууллагуудаас ирүүлсэн хариугүй 1305, хариутай 800 нийт 2105 албан бичгийг Able программд бүртгэлд авч, хугацаанд нь шийдвэрлүүлж, цахимаар болон цаасаар нийт 1159 албан бичгийг хариуг холбогдох газруудад хүргүүлэн, иргэн, алба хаагчдаас ажилд орох хүсэлт 1, шилжин ажиллах 19, захиргааны чөлөө 3, тэтгэвэр тогтоолгох 6, ажлаас гарах 1 нийт 30 өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, бүртгэлд авч хуулийн дагуу шийдвэрлэсэн.

9. Архивын нөхөн бүрдүүлэлтээр 2020 онд үүссэн байнга хадгалах 68, 70 жил хадгалах 8, түр хадгалах 204 баримтын хүлээн авч бүртгэлийг гарган батлуулсан. Байгууллагад түр хадгалах хугацаа дууссан 2017 оны байнга хадгалах хадгалах баримтыг цахим хувийн хамт Төрийн архивын байнгын хадгалалтад актын дагуу хүлээлгэн өгсөн. Төвийн Баримт нягтлан шалгах комиссын хурлыг 3 удаа хийсэн. Байгууллагад хадгалах хугацаа дуусаж түүх, эрдэм шинжилгээний болон практик ач холбогдолгүй болсон 81 боть хадгаламжийн нэгжийг төвийн БНШК-ийн хамт ялгаж, шатааж устган, архивын тоо бүртгэлийн баримт бичигт өөрчлөлт, хөдөлгөөн хийсэн.

10. Тус төв нь батлагдсан орон тоогоор офицер 136, ахлагч 17, энгийн 8, нийт 161 алба хаагч, ажилтан ажиллахаас өнөөдрийн байдлаар 155 алба хаагч ажиллаж, 6 орон тоо дутуу байна. Захиргааны удирдлагын хэлтэс 1 /энгийн гэрээт/, Шуурхай удирдлагын хэлтэс /102/ -2 /мэдээлэл хүлээн авагч/, Шуурхай удирдлагын хэлтэс /101,105/-2 /мэдээлэл хүлээн авагч/, Шуурхай удирдлагын хэлтэс /103/ -1 /ахлах зохицуулагч/, нийт 6 орон тоо дутуу байна. Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн хэвийн үйл ажиллагааг хангах, тусгай мэдлэг, мэргэжлийн ажлын байрны сул орон тоог нөхөх зорилгоор хүний нөөцийн 52 материалыг журмын дагуу судлан /шинээр томилогдсон 23, /бусад газраас шилжин ирсэн 16/, дэвшүүлэн томилсон 5, дотооддоо шилжүүлэн буюу зохицуулан томилогдсон 6, хүүхэд асрах чөлөө олгосон 3, хүүхэд асрах чөлөө цуцалсан 4, түр чөлөө цуцалсан 2, өндөр насны тэтгэвэрт тогтоолгосон 7, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн 1/ шийдвэрлүүлж, 1 алба хаагчийн материал судлагдаж байна. Тайлангийн хугацаанд төвийн даргын дэргэдэх зөвлөлийн хурал 22 удаа хуралдаж, удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэлээр 31, шагналын 71, хүний нөөцийн 52 асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр “А” тушаал 52, Хүний нөөцийн чиглэлээр “Б” тушаал 74-ыг албажуулсан.

11. Төвийн хэвийн үйл ажиллагааг хангах, хүн, хүчний хэрэгцээ шаардлагыг харгалзан тусгай мэргэжлийн албан тушаалын сонгон шалгаруулалтад 10 иргэн тэнцэн, нөөцөд бүртгэж, үүнээс 4 иргэнийг Шуурхай удирдлагын хэлтэс /103/-ийн мэдээлэл хүлээн авагч, зохицуулагчаар, 1 иргэнийг Техник ашиглалтын хэлтэст радио холбооны ашиглалт хариуцсан инженер албан тушаалд томилуулсан.

12. Төвийн даргын А/16 дугаар тушаалаар алба хаагчдыг хөгжүүлэх, тэдний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор ажлын байрны онцлогт тохирсон албаны сургалтыг зохион байгуулах “Сургалтын баг”-ийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, төвийн “2021 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-г 4 бүлэг 10 ажил арга хэмжээ хэрэгжүүлэхээр зайн болон цахим, танхим, дадлагын нийт 137 цагийн сургалт зохион байгуулахаар тус тус төлөвлөн батлуулан, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, хуваарийн дагуу мэдвэл зохих хууль тогтоомжийг судлах 43 удаагийн сургалтад давхардсан тоогоор 4988, алба хаагчийг хөгжүүлэх 25 удаагийн сургалтад давхардсан тоогоор 2799, дадлагажуулах 10 удаагийн сургалтад давхардсан тоогоор 917, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарсан 11 удаагийн сургалтад давхардсан тоогоор 910, нийт **89** удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор **9584** алба хаагчийг хамруулан ажиллалаа.

13. Сургалтуудыг зайн болон цахимаар 66, танхимаар 19, дадлага хэлбэрээр 4 удаа тус тус зохион байгуулж, зайн болон цахим сургалтыг тус төвийн <http://eincenter.mn/moodle> сургалтын систем болон “zoom” программ ашиглан зохион байгууллаа.

14. Алба хаагчдын сургалтын чанарыг дээшлүүлэх, мэдлэгийн түвшин тогтоох, судалсан хууль, эрх зүйн актуудын мэдлэгийг бататгах, шалгах зорилгоор сар бүр “Цахим” шалгалтыг зохион байгуулах ажлыг санаачлан хэрэгжүүлснээр алба хаагчдын шалгалтын дундаж үнэлгээ 1 дүгээр сард 66.4 байсан бол 11 дүгээр сарын үнэлгээгээр 84.1 болж 17.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

15. Төвийн даргын А/11 дугаартай тушаалаар “Соён гэгээрүүлэх баг” байгуулагдаж, ЦЕГ болон МДШШУА-ны 2021 онд алба хаагчдын дунд зохион байгуулах соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу төвийн төлөвлөгөөг батлуулан Мэдээлэл сурталчилгааны 69, соёл хүмүүжлийн 47 ажил, арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор **9646** алба хаагч хамрагдсан байна. Цагдаагийн байгууллагын 100 жилийн хүрээнд МДШШУА-ны хэлтсүүдийн дунд Сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулж эрэгтэй багаас 1, 2-р байр, эмэгтэй 6 багаас 1, 2 байрт тус тус шалгарсан байна.

16. Төвийн алба хаагчдын сэтгэл санааны байдлыг тодорхойлох 5 хэсгээс бүрдсэн багц сорилыг 112 алба хаагчаас, “Алба хаагчийн сэтгэл ханамж, байгууллагын үйл ажиллагаа” сэдвээр сэтгэл ханамжийн судалгааг 81 алба хаагчаас, хэлтсийн дарга нартай хамтран нийт 111 алба хаагчийн ар гэр, ахуй нөхцөлтэй танилцаж, санал хүсэлтийг сонсож, 147 алба хаагчаас амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг авч, үр дүнг танилцуулан, ЗУХ, ШУХ /102/, ШУХ /101,105/-ийн 5 алба хаагчид тусламж дэмжлэг үзүүлэх ажлыг төвийн даргын зөвлөлийн хуралд танилцуулж, сарын үндсэн цалинг 20 хувиар нэмж олгосон.

17. Оны байдлаар сахилгын зөрчил гаргасан 2, өөрийн хүсэлтээр албанаас чөлөөлөгдсөн 1, сэтгэл зүйн байдалд зөвлөгөө хүссэн 10, нийт 13 алба хаагчтай ганцаарчлан уулзаж, сахилгын шийтгэл хүлээсэн 2 алба хаагчтай хамтран ШУХ /102/-ийн 21 мэдээлэл хүлээн авагч нарын дунд “Алдааг амжилт болгоё” сэдэвт хэлэлцүүлгийг 4 удаа, Миний амьдралын тэнцвэр”, “Нөөцийн цэцэг” сэдэвт бүлгийн сургалтыг 4 удаа, Цагдаагийн ерөнхий газраас хэрэгжүүлж буй “Харилцаа-хандлага” аян, “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёл, эрүүл мэнд, сэтгэл зүйг төлөвшүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд лектор Ж.Баясгаланг урьж алба хаагчдын дунд “Хандлагын хүч”, “Байгууллагын хөгжил, соёл” сэдвээр 2 удаа сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 142 алба хаагчийг хамруулсан.

18. Төвийн Санхүү, аж ахуйн тасгаас 2020 оны жилийн эцсийн тайлан тэнцлийг гарган Хууль зүй, дотоод хэргийн яам, Үндэсний аудитын газарт хуулийн хугацаанд нь албан бичгээр хүргүүлж зөрчил дутагдалгүй дүгнэгдэн, Сангийн яамны э-тайлан, Үндэсний аудитын газар, Хууль зүй дотоод хэргийн яамны pre-баланс програмуудад төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өглөг авлагын тайланг шивж, цалингаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст, шилэн дансны хугацаат мэдээ мэдээллийг шилэн дансны сайтад тус тус хугацаанд нь тайлагнаж, байгууллагын 2022 оны төсвийн төсөл, 2023-2024 оны төсвийн төсөөлөл, хөрөнгө оруулалтын саналыг хэлтсүүдээс авч нэгтгэн боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хугацаанд хүргүүлж 2022 оны төсвийг 3,7 тэрбум төгрөгөөр батлуулсан.

19. 2021 оны худалдан авах төлөвлөгөөний дагуу 24 цагаар үүрэг гүйцэтгэн ажиллах алба хаагчдад хоол хүнс нийлүүлэх, шуурхай албаны автомашинуудад түлш шатахуун нийлүүлэх харьцуулалтын аргын тендер, багаж хэрэгсэл худалдан авах нээлттэй тендерүүд зарлаж, шалгаруулан, гэрээг байгуулж тендерийн үр дүнг www.tender.gov.mn цахим сайтад байршуулсан.

20. ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албаны Хангалт үйлчилгээний төвөөс өвөл, зуны улирлын 8 төрлийн 417 ширхэг хувцас хэрэглэлийн нэгдсэн хангалт, Шуурхай удирдлагын хэлтэс /101, 105/-ийн 29 алба хаагчид 15 сая төгрөгийн 11 төрлийн хувцасны хангалт, аж ахуйн 7 ажилтанд 1,9 сая төгрөгийн хөдөлмөр хамгааллын өвөл, зуны хувцасны хангалт олгож, 2020-2021 онд албанаас чөлөөлөгдсөн 2 алба хаагчийн хувцасны төлбөрийг барагдуулж, үлдэгдэлгүй ажилласан.

21. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын А-1/1203 тоот албан бичгээр ирүүлсэн зөвшөөрөл, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн даргын А/41 тоот тушаалаар баталсан байгууллагын үндсэн хөрөнгийн данс бүртгэлд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй 17 нэрийн

26,910,439 төгрөг 88 мөнгөний үнийн дүнтэй үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд бүртгэлтэй 66 нэрийн 16,021,626 төгрөгийн үнэ бүхий бараа материалыг Баянзүрх дүүргийн 24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах “Цагаан даваа”-ны төвлөрсөн хогийн цэгт устгаж, фото зургаар баримтжуулан, биелэлтийг тооцсон.

22. Хурлын танхимын гадна хананд агаар сэлгэх цонх гаргаж барилгын хийцэд өөрчлөлт оруулах боломжтой эсэх талаар Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, ЦЕГ-ын Санхүү аж ахуйн албанд албан бичгээр хандаж, ирсэн зөвлөмжийн дагуу засварын ажлыг 17 сая төгрөгөөр “Люкс сити” ХХК-аар чанартай бүрэн хийж гүйцэтгэсэн.

23. Алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, эрүүл мэндийг дэмжих зорилгоор төвийн байрны 101 тоот өрөө, 2, 3, 4 дүгээр давхруудын ариун цэврийн өрөөг орчин үеийн стандартад нийцүүлэн шинэчлэн тохижуулж, ариун цэврийн суултуурт автомат бидэ суулгаж засварлах ажлыг “Люкс сити” ХХК, “Толирант арт” ХХК, “Эй Ти Ди Ди” ХХК-уудтай гэрээ байгуулан засварын ажлыг нийт 46,6 сая төгрөгөөр хийж гүйцэтгүүлэн гүйцэтгэлийг актаар хүлээн авав.

24. Төвийн www.eincenter.mn цахим хуудсанд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2021 онд дэвшүүлсэн зорилт, Төвийн шинэчлэгдсэн дотоод журам, сургалт, зөвлөгөөн, ажил, арга хэмжээ, сарын төсвийн гүйцэтгэлийн тайлан шилэн дансны мэдээлэл гэх мэт нийт 29 мэдээ, мэдээллийг байршуулан, төвийн фейсбүүк цахим хуудас болон хаалттай цахим групп-т гэмт хэрэг, зөрчил, өвчлөл, Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлэг, тусгай дугаарын утаснуудад зохиомол ачаалал үүсгэх, тоглож залгах, хуурамч дуудлага, мэдээлэл өгөхийн хор уршиг, хариуцлагын талаар сэрэмжлүүлэг, “3 үгт хаяг”, мессежээр дуудлага, мэдээлэл өгөх, төвийн үйл ажиллагаа, сургалт, ажил, арга хэмжээний тухай мэдээ, мэдээлэл, шторк, постер бэлтгэн иргэд, олон нийтэд сурталчилж, Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос гаргасан зөвлөмж, шийдвэр, “102 тусгай дугаарын утсанд ирсэн дуудлага, мэдээллийн хоногийн нөхцөл байдлын тоон мэдээ”, гэмт хэрэг, зөрчил, өвчлөл, гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, шалгаж байгаа болон цагдаагийн бусад нэгж, байгууллагаас гаргасан 526 контент, постер, танилцуулга, мэдээ, мэдээллийг нийтэлж, иргэд олон нийтэд мэдээлэл хүргэж ажиллалаа.

25. Тусгай дугаарын утаснуудад тоглож залгасан дуудлагын бүртгэлийг улирлаар гаргаж, тоглож залгасан 24 хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчтай утсаар холбогдон сануулга, зөвлөгөөг өгч, Чингэлтэй дүүргийн цагдаагийн газрын Нэгдүгээр хэлтсийн хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаа зохицуулагч нарын хамт Ерөнхий боловсролын “Тусгал”, 5, 50, 23, 24 дүгээр сургуулиудын 1-5 дугаар ангийн 1261 сурагчдад гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, төвийн тусгай дугаарын 101, 102, 103, 105 утсанд яаралтай тусламжийн дуудлага мэдээлэл хүлээн авдаг тул тоглож залгаж болохгүй талаар сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэсэн.

26. Төвийн ШУХ /102/, ШУХ /103/, ШУХ /101,105/ тусгай дугаарын утсанд иргэд байгууллагаас ирүүлж буй гэмт хэрэг, зөрчил, гал түймэр, гамшиг осол, эмнэлгийн яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг хүлээн авч бүртгэх, дамжуулах мэдээлэл хүлээн авагчдын харьцаа хандлага, ёс зүй, үйлчилгээний соёл, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх үйл ажиллагаанд өгөх үнэлэлт дүгнэлтийг гаргах чиглэлээр тусгай дугаарын утаснуудад дуудлага, мэдээлэл өгсөн нийт 450 иргэнээс санал авч, дүнг нэгтгэхэд судалгаанд оролцогчдын 99% нь яаралтай тусламжийн дуудлага мэдээлэл хүлээн авч буй мэдээлэл хүлээн авагчдын харьцаа хандлага, үйлчилгээний соёлын талаар маш сайн, сайн гэж дүгнэсэн.

27. Төвийн даргын А/03 дугаар тушаалаар Коронавируст “Ковид-19” халдвараас алба хаагчдыг урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг зохион байгуулах, сэжигтэй тохиолдол илэрсэн үед хариу арга хэмжээ авах ажлыг зохион байгуулах багийг

байгуулан, ахуйн шавж, мэрэгчийн устгал, халдваргүйжилтийн албаны “Хунт-Хайрхан” ХХК-аар 8 удаа, “СООСУ” ХХК-аар 2 удаа, Зоонозын өвчин судлалын төвийн халдваргүйтгэлийн багаар 3 удаа, Цагдаа, дотоодын цэргийн түр хүрээгээр 7 удаа нийт 20 удаа төвийн байрны бүх өрөө тасалгаанд голомтын дараах халдваргүйтгэл хийлгүүлж, алба хаагчдын дархлааг дэмжих, халдвараас хамгаалах, дархлаа дэмжих зорилгоор Салимон 300 ширхэг, нэг удаагийн маск 21800 ширхэг, KN-95 маск 3100 ширхэг, KN-94 маск 2930 ширхэг, уушиг цэвэрлэх цай 441 ширхэг, цагаан гаатай цай 137 ширхэгийг, “Цэнэг” дархлаа дэмжих бүтээгдэхүүн 300 ширхэг, “Өтгөрүүлсэн чацаргана”-ны шүүс 445 ширхэг, Зөв аарц 442 ширхэг, витагрип 440 ширхэг, нүдний хиймэл нулимс 3 удаа алба хаагчдад олгож, хүзүү мөрний хуянг, эмчлэх зориулалт бүхий 2 төрлийн 5 ширхэг төхөөрөмжийг байрлуулах болон эм тарианы нөөцийг 5 удаа бүрдүүлэхэд төвөөс 19,463,000 төгрөг, алба хаагчдын дундын сангаас 1,088,000 төгрөг тус тус зарцуулан ажилласан.

28. Мөн төвийн 154 алба хаагчаас “Ковид-19” халдварын эсрэг вакцинд 1 дүгээр тунд 99,3 хувь, 2 дугаар тунд 99.3 хувь, 3 дугаар тунд 92.8 хувьтай тус тус хамруулсан нэгдсэн журмаар 9 удаа давхардсан тоогоор 1041 алба хаагчийг халдварын эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн болон ойрын хавьтал болсон алба хаагчдыг шинжилгээнд хамруулж, эрт илрүүлэлт, эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлыг амжилттай зохион байгуулж, /Ковид 19/-ын өвчнөөр халдварласан 80 алба хаагчаас гэрээр өрхийн эмчийн хяналтад 69 алба хаагч, эмнэлэгт 11 алба хаагч хэвтэж эмчлүүлсэн.

Хоёр: Дуудлага, мэдээлэл хүлээн авах чиглэлээр:

29. “Цагдаагийн байгууллагын хоногийн нөхцөл байдлын мэдээ”-г Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Хууль зүй дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны дарга нарт цаасаар, Төрийн тусгай хамгаалалтын газар, Тагнуулын ерөнхий газарт, Улсын ерөнхий прокурорын газарт цахимаар нийт 340 удаа хүргүүлсэн.

30. /102/ тусгай дугаарт Улсын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлийн талаарх 438.195 дуудлага, мэдээллийг хүлээн авснаас хэв журмын зөрчил 289.740, гэмт хэргийн 12.654, сураггүй алга болсон хүн 3.295, олдсон хүүхэд /хүн/ 2111, хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн 44.139, зам тээврийн осол, хэргийн 93.312, үүнээс гадаадын иргэнтэй холбоотой 252, архидан согтуурсантай холбоотой 131.271, цагдаагийн алба хаагчтай холбоотой 974, хар тамхи, мансууруулах бодистой холбоотой 183 дуудлага мэдээлэл бүртгэж, хулгайн 3.541, хүүхэд гэр бүлийн хүчирхийллийн 42,924 дуудлагын шийдвэрлэлт, очсон хугацаанд хяналт тавьж, хулгайлах гэмт хэргийн дуудлага өгсөн 3.242, хүүхэд гэр бүлийн хүчирхийллийн дуудлага өгсөн 16,644, сураггүй алга болсон гэж мэдээлэл өгсөн 3.163, нийт 23.049 иргэнтэй холбогдож, гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээллийн шийдвэрлэлтэд хяналт тавьж, хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хамгаалах, холбогдох байгууллагад холбон зуучлах, дахин хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хүүхдийн тусламжийн 108 дугаараас 102 тусгай дугаарт ирүүлсэн 2159 дуудлагыг хүлээн авч, орон нутаг болон дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсээс зарлуулсан 225 мэдээллийг Цагдаагийн байгууллагын дотоод сүлжээгээр зарлан мэдээлж, хамтран ажилласан ба шуурхай удирдлагын хэлтсүүд хооронд шилжүүлсэн нийт 6198 дуудлагад хяналт тавин ажилласан.

31. /101,105/ тусгай дугаарт 3.183 мэдээлэл бүртгэгдсэнээс гал түймрийн 2,609, аврах ажиллагааны 582 мэдээлэл, бүртгэж 1.410 дуудлага, мэдээллийг ангилж,

объектын гал түймрийн 1246, аврах ажиллагааны 164 дуудлага, мэдээллийг бүртгэн, хоногийн нөхцөл байдлын мэдээг Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн онцгой байдлын газрын удирдлагад 332 удаа танилцуулж, 367 удаагын гал түймрийн хэргийн газрын үзлэгт хууль, хяналтын байгууллагатай хамтран ажиллаж, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албад, гал түймрийн улсын хяналтын байцаагчаас шинжээч томилох, шинжилгээ хийлгэхээр ирүүлсэн 228 тогтоолыг хүлээн авч 221 дүгнэлт гаргаж хүргүүлсэн.

32. /103/ тусгай дугаарт нийт 1,048,252 хандалт бүртгэгдсэнээс эмнэлгийн яаралтай түргэн тусламжийн 272,743 дуудлага мэдээлэл хүлээн авч, шуурхай удирдлага зохицуулалтаар хангаж ажилласан байна. Үүнээс өвчин эмгэгийн 207,963 дуудлага, төрөх эмэгтэйчүүдийн 15,708, осол гэмтлийн 49,099 дуудлага байна. Эрүүл мэндийн анхан шатны зөвлөгөөг 129,969 иргэнд өгч, хүүхдийн 295,962 дуудлага мэдээллийг Нийслэлийн түргэн тусламжийн төв, түүний салбаруудад, онцлог мэдээллийн талаар Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Онцгой нөхцөл байдал, шуурхай удирдлага зохицуулалтын хэлтэст 13,081 мэдээлэл, Эрүүгийн цагдаагийн албаны жижүүрт 679 мэдээлэл, Мөрдөн байцаах албаны жижүүрт 505, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Дотоод аюулгүй байдлын хэлтэст 596 мэдээллийг дамжуулж ажилласан.

Гурав: Мэдээллийн технологийн чиглэлээр:

33. E1N системийн тогтвортой ажиллагааг хангаж ажиллах чиглэлээр давхардсан тоогоор 525 үзлэг, үйлчилгээ, 483 засвар, 684 өргөтгөл суурилуулалтын ажлыг зохион байгуулсан.

34. Өөрийн хаяг, байршлаа мэдэхгүй байгаа иргэнд яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын “What3words” компанитай хамтран ажиллах “Санамж бичиг”-ийг байгуулж, санамж бичгийн хүрээнд “3 үгт хаяг”-ийн аргачлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, мэдээлэл хүлээн авагч нарт сургалт зохион байгуулж, системийн тусламжтай хаяг байршлаа мэдэхгүй 18 иргэнийг тодорхойлж, тэдгээрийн амь нас, эрүүл мэндийг авран хамгаалах нөхцөлийг бүрдүүлсэн.

35. Утсаар залгаж яаралтай тусламжийн дуудлага, мэдээлэл өгөх боломжгүй нөхцөл байдалд орсон, *гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, барьцаалуулсан, гэмт этгээд дэргэд нь байгаа* иргэнээс дуудлага, мэдээллийг богино зурвас /мессеж/-аар авах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр яаралтай тусламжийн E1N системд өргөтгөл суурилуулалт хийж, үйл ажиллагаанд нэвтрүүлэн, өмнө нь гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл өгч байсан 31,000 иргэнд богино зурвасаар мэдээлэл хүргэж, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 182 иргэнээс богино зурвас /мессеж/-аар дуудлага мэдээлэл хүлээн авч, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүдэд дамжуулан, тэдгээр иргэдийг учирч болзошгүй хор, хөнөөлөөс авран хамгаалсан.

36. Хууль зүй дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Шадар сайд нар Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагаатай 2021.03.31-ний өдөр танилцаж, яаралтай тусламжийн дуудлага, мэдээлэл хүлээн авах тусгай зориулалтын системийг шинэчлэхэд шаардлагатай зардлыг шийдвэрлүүлэн ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албаны даргын А/54 дүгээр тушаалаар худалдан авах ажлыг зохион байгуулах, нийлүүлэгчийг сонгох, гүйцэтгэлд хяналт тавих, хүлээн авах ажлын хэсгийг байгуулж, гүйцэтгэгчээр “Энжинэкс” ХХК-ыг сонгон шалгаруулан “Genesys Pure Connect” дуудлагын төвийн иж бүрэн програм, тоног төхөөрөмжүүдийг хүлээн авч, яаралтай тусламжийн дуудлага, мэдээлэл хүлээн авах технологийн хамгийн сүүлийн үеийн техник технологиор иж бүрэн шинэчлэгдэн иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, тасралтгүй үзүүлэх боломж бүрдсэн.

37. Яаралтай тусламжийн дуудлага, мэдээлэл хүлээн авах E1N системийн хэвийн тогтвортой ажиллагааг хангах шилэн кабелин дэд бүтцийг өргөтгөх ажлын хүрээнд Нийслэлийн онцгой байдлын болон Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газруудтай шилэн кабелин дэд бүтэц хамтран ашиглах санал, санаачлалыг гаргаж төсөв, зардалгүйгээр тус дүүргийн 20, 23 дугаар хороо Хужирбулан, Гачуурт чиглэлд татагдсан гэмтэлтэй 13,8 км агаарын шилэн кабелиг засварлаж, Нийслэлийн онцгой байдлын газрын харьяа гал түймэр унтраах, аврах 35-р анги, Гачууртад байрлах 4,9Гц-ийн утасгүй сүлжээний бааз станц, Хужирбуланд байрлах Цагдаагийн түр постыг өндөр хурдны шилэн кабель ашиглан дуудлага, мэдээлэл хүлээн авах E1N системд холбосон. Мөн төвийн 2021 оны урсгал зардлаар Баянхошуу чиглэлийн 4000 метр агаарын шилэн кабелиг шинэчилэн цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагуудыг нэгдсэн сүлжээнд холбох ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд 6 объектыг шинээр холбож, Цагдаагийн байгууллагын ажил, үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, алба хаагчдад Цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээг хүртээмжтэй ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн.

38. Төвийн 5 дугаар давхарт байрлах серверийн өрөөний ашиглалтыг сайжруулах, тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тус хэлтсийн инженер, техникийн ажилчид төлөвлөгөөний дагуу серверийн өрөөнд байрлах сервер, сүлжээ, камер, тоон радио холбоо, телефон холбооны тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг хангах, үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлж тоног төхөөрөмжүүдийн виртуал тохиргоог хуулбарлах, төвийн босоо, хэвтээ сувагчлалын дагуу кабелуудыг цэгцлэх, шилжүүлэх, гэрэлтүүлгийн цахилгаан монтажийг шинэчлэх, штабын болон серверийн өрөөний электрон цоожны системийн төхөөрөмжүүдийг зориулалтын хайрцагт суурилуулах, хуучин, актлагдсан хөргөлтийн системийн ашиглалтгүй хоолойнуудыг буулгах, дотоод заслыг хийж гүйцэтгэсэн.

39. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.2-т заасны дагуу “Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон сум, суурин газруудын гудамж, зам, талбайг камержуулах төсөл”-ийг Олон улсын жишигт нийцүүлэн гудамж, зам, талбай, олон нийтийн газруудыг камерын хяналтад авах, хиймэл оюун ухаанд суурилсан ухаалаг платформ системтэй хэрэгжүүлэхээр төслийг шинэчлэх, ЦЕГ-ын даргын А/205 дугаартай тушаалаар “Гудамж, замыг орчин үеийн техник, технологи бүхий хяналтын камер, тоног төхөөрөмжөөр тоноглох, мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох, замын хөдөлгөөнийг хянах, зохицуулах нэгдсэн хяналтын төвийг байгуулах, өмнөх жилүүдэд тавигдсан, гэмтэл сааталтай хяналтын камеруудыг хэвийн ажиллагаанд оруулахад шаардагдах зардлын тооцоог гаргах, замын хөдөлгөөнд оролцогчдын сахилга, соёлыг хэвшүүлэх, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн, орчинг боловсронгуй болгох” санал бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж “Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илрүүлэх, бүртгэх, хяналт тавих нэгдсэн системийн төсөл”-ийн баримт бичгийг шинээр тус тус боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн сайдад танилцуулж, төслийг хүлээлгэн өгсөн.

40. Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Их Хурлын 18, 28 дугаар тойрогт нөхөн сонгууль, Улаанбаатар хотод нийтийг хамарсан жагсаал, цуглаан, эмх замбараагүй байдал үүсэж болзошгүй эрсдэлтэй 23 цэг, Улаанбаатар хотоос гарах, орох 7 пост, Дэлхий нийтэд “КОВИД-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдийг тусгаарлан ажиглах 16 байрны гадна орчныг камерын хяналтад авах, цагдаагийн байгууллагын 4,9Гц-ийн утасгүй сүлжээ, “Скайнетворкс” ХХК-ний шилэн кабелин сүлжээг ашиглан цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээнд холбож, камерын дүрсийг ЦЕГ-ын Шуурхай удирдлагын штабт хянах боломжийг бүрдүүлэн, хэвийн ажиллагааг ханган ажилласан. Мөн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/48 дугаар тушаалаар батлагдсан “Дүрс бичлэгийн техник хэрэгслийг цагдаагийн

байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох журам”-ын хэрэгжилтийг хангах чиглэлээр Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны дарга, Эрүүгийн цагдаагийн албаны дарга нарын хамтарсан “Махны үйлдвэр, мал нядалгааны газруудад теле хяналт тогтоох” төлөвлөгөөний дагуу Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны “Эмээлт”-д үйл ажиллагаа явуулж байгаа 44 мах боловсруулах үйлдвэр, мал нядалгааны газруудын камерын хяналтад авах ажлыг зохион байгуулсан.

41. Яаралтай тусламжийн дуудлага, мэдээлэл хүлээн авах “112” нэгдсэн дугаарлалтын систем нэвтрүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, техникийн шийдлийн судалгааг хийж Хууль зүй, дотоод хэргийн сайд, Засгийн газрын хуралдаанд танилцуулж дэмжигдэж, Засгийн газрын хуралдаанаас гаргасан шийдвэрийн дагуу “Яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийн дугаарлалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын төслийг бэлтгэж Хууль зүй, дотоод хэргийн сайдын 1/3952 албан бичгээр яамд бусад холбогдох төрийн байгууллагуудаас санал авч нэгтгэсэн ба 2022 оны 1 дүгээр улиралд багтаан яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг нэгдсэн дугаарлалтаар хүлээн авах ажлыг эхлүүлэхээр тусгагдсан байна.

Дөрөв. Дүгнэлт

Гэмт хэрэг, зөрчил, гамшиг осол, гал түймэр, эмнэлгийн түргэн тусламж зэрэг дуудлага, мэдээлэл хүлээн авах, бүртгэх, дамжуулах тусгай зориулалтын телефон холбооны системийг шинэчлэх талаар ЦЕГ-ын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, ОБЕГ-ын дарга нарт танилцуулж, шаардлагатай 720 сая төгрөгийн зардлыг 3 сайдын багцаас шийдвэрлүүлж, телефон холбооны системийн тоног төхөөрөмжийг суурилуулж, системийг бүрэн шинэчилснээр сүүлийн үеийн дэвшилтэд технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн үр дүнтэй ажил болсон.

Тус төв нь Монгол Улсын Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас гаргасан бодлогын баримт бичгүүд, хөтөлбөр, төлөвлөгөө, Цагдаагийн ерөнхий газраас 2021 онд дэвшүүлсэн зорилт, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны болон төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, дамжуулах, шуурхай удирдлагаар хангах, төрөл мэргэжлийн албадын үйл ажиллагааг уялдуулан холбох үйл ажиллагааны чанар, үр дүнг ахиулж, хуулиар хүлээсэн үүргээ “Хангалттай” гүйцэтгэсэн гэж дүгнэж байна.

Тав. Цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ

Төвийн үйл ажиллагаа, төлөвлөлт, зохион байгуулалтын ажлыг сайжруулах зорилгоор 2021 онд хэрэгжүүлсэн ажилд дүн шинжилгээ хийж, 2022 онд бодлогын чанартай хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг төв, хэлтэс, алба хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах, биелэлт үр дүнг тайлагнах, алба хаагчдыг бодитоор үнэлэх, ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг төвийн даргын тушаалаар байгуулж ажиллуулах;

Яаралтай тусламжийн дуудлага, мэдээлэл хүлээн авах үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор яаралтай тусламжийн нэгдсэн нэг дугаарлалтад шилжүүлэх, сүлжээний тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх саналыг хүргүүлж шийдвэрлүүлэх.

Гэмт хэрэг, зөрчил, гал түймэр, гамшиг осол, эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх үйл ажиллагааг боловсронгуй болгож, мэдээлэл хүлээн авагчдын ур чадварыг дээшлүүлэх.